Бичсэн .
2013 оны 9-р сарын 18, Лхагва гариг, 07:16 - Сvvлд шинэчлэгдсэн 2013 оны 9-р сарын 18, Лхагва гариг, 07:20

Тов, орон нутгийн архивын ажлыг сайжруулах арга хэмжээний тухай БНМАУ-ын Сайд нарын Зовлол, МАХН-ын Тов Хорооны 1957 оны 2 дугаар 09-ний одрийн 92/66 дугаар тогтоолоор архивын хэргийг товлорvvлэн, тvvний хадгалалтыг сайжруулах, архивын баримт бичгийг улс нийгэм, соёл, шинжлэх ухааныг хогжvvлэх сонирхлын vvднээс ашиглах явдлыг хангахын тулд тvvх соёлын баримт материалыг аймаг, хотын архивт товлорvvлэн, улсын архивын нэгдсэн фондыг бий болгох тогтоолын дагуу улс орны хэмжээнд архивын хэргийг удирдан зохион байгуулах чиг vvрэг бvхий торийн захиргааны байгууллага, аймаг орон нутгийн улс архивууд байгуулагдаж, аймаг орон нутгийн хэмжээнд архивын сан хомрогийн баримтыг байгууллага, он цагийн хамаарлаар ангилах фонд vvсгэх, эмхлэн цэгцлэх, данс бvртгэлд оруулах ажлыг хийж эхэлсэн.

1970-1990 онд  Улсын архивын болон байгууллагын архивын ажлын заавар, баримт бичиг хадгалах хугацааны vлгэрчилсэн жагсаалт, албан хэрэг хотлолтийн журам, стандартыг vе vе шинэчлэн баталж мордvvлэн, Архивын баримт бичгийг товлорсон хадгаламжинд шилжvvлэх ажлыг зохион байгуулснаар торийн архивын сан хомрог тvvх эрдэм шинжилгээний ач холбогдолтой орчин цагийн баримтаар нохон баяжигдаж,  архив судлал, хэвлэн нийтлэх vйл ажиллагаа идэвхтэй орнож, тов орон нутгийн архив, албан хэрэг хотлолтийг шалган зааварлах, мэргэжил арга зvйгээр удирдах зохион байгуулалтын нэгдсэн систем тогтсон байна.

1990 оноос ардчилал шинэчлэлийн жилvvдэд архивын баримтыг ил тод, нээлттэй болгох талаар чухал алхам хийгдэж их бага хувьчлалаар хувьчлагдсан болон татан буугдсан, улсын vйлдвэр, аж ахуйн байгууллагын баримт бичгийг торийн архивт шилжvvлэн авах ажил эрчимтэй орносон.

1958-1990 онуудад ажиллаж байсан аймгийн Улсын архивын эрхлэгч Шагдар, Чойсvрэн,Цэенхvv, Бааст, С.Мул, М.Отгонхишиг нарын нор их ходолморийн vр дvнд архивын сан хомрогийн баримт бичгvvд нь эмхлэгдэн зааврын дагуу цэгцлэгдэж иржээ.

*Аймгийн Төрийн архивын  удирдлага, зохион байгуулалт*

Аймгийн архив анх аймгийн АДХ-ын гvйцэтгэх захиргааны конторын vvдэнд байсан /хуучин хотын захиргаа/ хондлон цагаан байшинд байж байгаад, 1962 оноос Баазын бага сургууль нэртэй байсан одоогийн 36 айлын орон сууцны тэнд очиж байрлаж байгаад

дахин аймгийн АДХ-ын гvйцэтгэх захиргааны нэгдсэн конторт байрлаж байгаад талбай багадаж 1972 онд аймгийн Нийтийн номын санд нvvж байрлаж байгаад 1980-аад оноос дахин АДХ-ын гvйцэтгэх захиргааны байранд нvvж байрлаж байсан.

Аймгийн АДХ-ын гvйцэтгэх захиргааны 1989 оны 2 дугаар тогтоолоор аймгийн Улсын архивын дэргэдэх биеэ даасан аж ахуйн тооцооны 4 хvний орон тоотой групп байгуулагдан ажиллах журмыг боловсруулан батлуулжээ.

1991 оны 1 дvгээр сараас эхлэн аймгийн АДХ-ын гvйцэтгэх захиргаанаас аймгийн Хууль зvйн хэлтсийн харъяанд шилжсэн.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 24 тоот тогтоолын дагуу 1992 оны 10 дугаар сарын 7-ноос зохион байгуулалт хийгдэж Хууль зvйн хэлтсээс аймгийн Засаг даргын Тамгын газрын харъяалалд ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 124 дvгээр тогтоолын 2, Үндэсний архивын газрын 1998 оны 167 дугаар тоотын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн архивын тасаг нь тасгийн дарга, сан хөмрөгийн эрхлэгч гэсэн 2 орон тоотойгоор зохион байгуулагдаж, Архивын тасаг нь Тамгын газрын даргын 1999 оны 4 дvгээр сарын 16-ны өдрийн 17 тоот тушаалаар архивын тасгийн дvрмийг батлуулж мөрдөн ажиллаж байна.



2000-2007 он хvртэл аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа,

удирдлагын хэлтэст Архивын тасаг, Засгийн газрын 2007 оны 25 дугаар тогтооллоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зvйн хэлтсийн бvрэлдэхvvнд орж тасгийн дарга, Сан хомрогийн эрхлэгч, архивч/ гэрээт ажилтан/ гэсэн орон тоотойгоор ажиллаж байгаад Засгийн газрын 2010 оны 261 дvгээр тогтоолоор Архивын тасагт гэрээт ажилтанг нэмж ажиллуулахаар шийдвэрлэсэн дагуу 5 гэрээт ажилтанг томилон ажиллуулж байна.

2004-2008 оны аймгийн Засаг даргын vйл ажиллагааны хотолборт архивын тасгийн чиглэлээр асуудал тусгуулснаар Архивын тасгийн сан хомрогийн ороонvvдэд утаа болон ходолгоон мэдрэгчийг 1 сая тогрогний ортогтэйгээр, 5 сая тогрогний ортогтэйгээр нягтруулсан замтай шvvгээ зэргийг тус суурилуулсан, иж бvрэн компьютер 2 ширхэг, канон 1, скайнер 1, проектер 1 ширхэг, Сан хомрогийн ороонvvдийн модон шалыг сольж, чулуун хавтангаар хучиж, уншлагын ороог шинээр гарган тохижуулахад 12 сая тогрог зарцуулжээ, 2009-2012 онд аймгийн Засаг даргын vйл хажиллагааны хотолборт аймгийн хэмжээнд архив, албан хэрэг хотлолтийн чиглэлээр асуудлыг тусгаснаас 5 ширхэг компьютер, 2 ширхэг нягтруулсан шvvгээ, 5 ширхэг, ширээ сандал, зургийн аппарат зэрэг 17 сая тогрог зарцуулснаас гадна архивын гар ажиллагааг цахим хэлбэрт шилжvvлэхэд ихээхэн анхаарч 17 сумдын Засаг даргын Тамгын газар, 12 байгууллагуудад байгууллагын архивын “ ORG-AMS” программ, Торийн архивын тасаг торийн архивын “ERMS ” программыг тус тус суулгасан байгууллага иргэдэд архивын баримтаар vйлчлэх vйлчилгээ чирэгдэлгvй хурдан шуурхай болж байна.

*Сан хөмрөгийн нөхөн бvрдvvлэлт*

Аймгийн Торийн архивын сан хомрогт vндсэндээ Сум, байгууллагуудын удирдлагын vйл ажилагааны явцад vvссэн, Шинжлэх ухаан технологи, Хувийн гаралтай цаасан суурьтай болон фото суурьтай 142 хомрогийн 37000 ширхэг хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

1989 онд 10 байгууллага, 1990 онд 21 байгууллагын архивын баримт бичгийг зааврын дагуу эмхлэн цэгцлэх ажлыг гvйцэтгэж, 1990 онд 1822 байнга хадгалах хадгаламжийн нэгжээр, 1992 онд шинээр фото зургийн сан хомрог vvсгэж жvжиг, драмын жvжиг, концертын 546 фото зураг, хотолбор, аймгийн танилцуулга, мон тvvхт дурсгалт газар, баяр наадмын болон судалбар зургийн 181 фото зурагаар, 1995-2000 онд хувьчлагдсан сумдын 1980-1997 оны байнга болон 70 жил хадгалах баримтууд татан авч эмхлэн цэгцлэх ажлыг хийж, шинээр хомрог vvсгэн, данс бvртгэл vйлдсэн.

Бичсэн .
2013 оны 9-р сарын 18, Лхагва гариг, 07:16 - Cvvлд шинэчлэгдсэн 2013 оны 9-р сарын 18, Лхагва гариг, 07:20



[illegible]